

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2024/209/-НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМАГ АЛТАНБУЛАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2023
ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН
АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2024 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор Ж.Бямбацогт

Утас: 70273204 Цахим хаяг: byambatsogtj@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

Товчилсон үгийн жагсаалт	3
1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	4
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	6
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	14
4. АУДИТЫН ТАЙЛАН	19
4.1 Ерөнхий зүйл	19
4.2 Материаллаг байдал.....	19
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	19
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	19
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	19
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	20
4.5.1 Завсрын аудитын талаар.....	20
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	20
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	21
5.1 Төлбөрийн акт	21
5.2 Албан шаардлага.....	22
5.3 Зөвлөмж.....	22
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	23

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ТӨВ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2024.02.23 № 01/58
танай _____-ны № _____-т

ТӨВ АЙМГИЙН АЛТАНБУЛАГ
СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
Д.БАТЖАРГАЛ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Алтанбулаг сумын Засаг даргын тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Алтанбулаг сумын Засаг даргын тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд өөрийн орлогыг давуулан биелүүлсэн ба үйл явцыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд орхигдуулсан асуудал гараагүй болно. Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна.

Аудитын гол асуудал

Арилжааны банкны харилцах данс болон кассын 1,668.9 мянган төгрөгийн ажил гүйлгээ бүртгээгүй, урьдчилгаа төлбөр 9,926.1 мянган төгрөгийг өглөг дансанд бүртгэсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал гараагүй болно. Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

G/Arkhir/Alban bichig 2024/ A4

019020176

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

G/Arkhir/Alban bichig 2024/ A4

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	233,588,496.7	129,000,864.0
33	АВЛАГА	159,000,000.0	22,000,000.0
335	Бусад авлага	159,000,000.0	22,000,000.0
3351	Байгууллагаас авах авлага	159,000,000.0	22,000,000.0
35	БАРАА МАТЕРИАЛ	74,588,496.7	107,000,864.0
351	Түүхий эд материал	0.0	17,000,000.0
35110	Тусгай зориулалттай материал	0.0	17,000,000.0
354	Хангамжийн материал	69,588,496.7	85,000,864.0
35420	Аж ахуйн материал	69,588,496.7	85,000,864.0
35600	Мал амьтад	5,000,000.0	5,000,000.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	10,026,909,109.6	9,263,213,639.5
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	10,026,909,109.6	9,263,213,639.5
392	Биет хөрөнгө	9,972,181,109.6	9,206,035,639.5
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,694,929,589.4	1,995,718,280.4
39202	Хуримтлагдсан элэгдэл	-675,431,483.6	-778,411,599.0
39203	Авто-тээврийн хэрэгсэл	446,252,332.6	476,252,332.6
39204	Хуримтлагдсан элэгдэл	-211,922,817.5	-244,454,024.3
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	204,146,270.0	232,485,590.0
39206	Хуримтлагдсан элэгдэл	-123,078,431.8	-141,018,924.4
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	59,586,265.0	71,839,033.0
39208	Хуримтлагдсан элэгдэл	-47,324,382.7	-49,399,649.3
39209	Зам, гүүрийн байгууламж	10,674,041,626.0	10,684,041,626.0
39210	Хуримтлагдсан элэгдэл	-2,249,045,648.5	-3,300,011,447.8
39214	Бусад үндсэн хөрөнгө	319,551,133.5	418,099,463.5
39215	Хуримтлагдсан элэгдэл	-141,341,542.8	-180,923,241.2
39217	Ном	21,818,200.0	21,818,200.0
393	Биет бус хөрөнгө	54,728,000.0	57,178,000.0
39303	Бусад биет бус хөрөнгө	64,328,000.0	64,578,000.0
39304	Хуримтлагдсан элэгдэл	-9,600,000.0	-7,400,000.0
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	10,260,497,606.3	9,392,214,503.5
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	10,260,497,606.3	9,392,214,503.5
51	Засгийн газрын хувь оролцоо	10,260,497,606.3	9,392,214,503.5
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	733,779,241.5	733,779,241.5
51101	Өмч: - төрийн	733,779,241.5	733,779,241.5
512	Хуримтлагдсан үр дүн	9,145,158,212.8	8,276,875,110.0
51210	Өмнөх үеийн үр дүн	9,145,158,212.8	9,145,158,212.8
51220	Тайлант үеийн үр дүн	0.0	-868,283,102.8
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	381,560,151.9	381,560,151.9
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	10,260,497,606.3	9,392,214,503.5

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,223,992,845.7	1,292,611,923.3
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	396,078,051.2	427,757,021.0
120	Нийтлэг татварын бус орлого	396,078,051.2	427,757,021.0
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	396,078,051.2	427,757,021.0
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	396,078,051.2	427,757,021.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	827,914,794.5	864,854,902.3
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	329,731,494.5	106,589,402.3
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	100,000,000.0	0.0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	170,924,936.0	58,842,982.0
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	58,806,558.5	47,746,420.3
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	498,183,300.0	758,265,500.0
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	498,183,300.0	758,265,500.0
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,893,568,213.2	2,158,345,793.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,872,434,291.2	1,994,953,633.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,758,743,415.0	1,960,105,300.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	258,723,361.7	459,146,271.2
210101	Үндсэн цалин	197,230,127.7	295,312,158.7
210102	Нэмэгдэл	34,462,206.7	102,422,113.2
210103	Унаа хоолны хөнгөлөлт	342,000.0	0.0
210104	Урамшуулал	22,513,570.5	61,411,999.3
210105	Гэрээт ажлын хөлс	4,175,456.8	0.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	35,795,066.7	56,676,935.2
210201	Тэтгэврийн даатгал	25,534,000.9	38,211,919.8
210202	Тэтгэмжийн даатгал	2,566,891.2	4,643,854.2
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,099,502.5	3,715,083.3
210204	Ажилгүйдлийн даатгал	529,874.0	927,193.5
210205	Эрүүл мэндийн даатгал	5,064,798.1	9,178,884.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	57,555,370.5	75,657,446.7
210301	Гэрэл, цахилгаан	14,511,868.0	20,366,058.7
210302	Түлш, халаалт	42,793,502.5	54,991,388.0
210303	Цэвэр, бохир ус	250,000.0	300,000.0
2104	Хангамж, бараа материалын зардал	35,152,788.0	42,161,076.0
210401	Бичиг хэрэг	1,781,050.0	3,043,300.0
210402	Тээвэр, шатахуун	26,607,528.0	30,802,376.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,644,210.0	2,683,000.0

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,120,000.0	5,632,400.0
2105	Нормативт зардал	0.0	860,000.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	0.0	860,000.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,147,000.0	3,369,660.0
210604	Урсгал засвар	10,147,000.0	3,369,660.0
2107	Томилолт, зочны зардал	3,092,600.0	4,570,000.0
210702	Дотоод албан томилолт	3,092,600.0	4,570,000.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	15,307,769.4	6,295,013.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	13,796,366.4	5,322,000.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432,000.0	0.0
210803	Даатгалын үйлчилгээ	304,425.0	318,375.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	609,978.0	522,638.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	165,000.0	132,000.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,342,969,458.7	1,311,368,898.5
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	78,997,090.0	53,102,507.4
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	1,263,972,368.7	1,258,266,391.1
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	113,690,876.2	34,848,332.8
2132	Бусад урсгал шилжүүлэг	63,225,498.0	5,485,000.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	8,486,347.0	0.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	54,739,151.0	5,485,000.0
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	50,465,378.2	29,363,332.8
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	21,133,922.0	163,392,160.0
2200	Дотоод эх үүсвэрээр	21,133,922.0	163,392,160.0
220001	Барилга байгууламж	0.0	150,000,000.0
223001	Бусад хөрөнгө	21,133,922.0	13,392,160.0
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-669,575,367.6	-865,733,870.1
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	2,247,086.8	2,549,232.7
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	240,766.9	30,000.0
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	2,006,319.8	2,519,232.7
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-2,247,086.8	-2,549,232.7
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-671,822,454.3	-868,283,102.8

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	827,914,794.5	864,854,902.3
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	827,914,794.5	864,854,902.3
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	329,731,494.5	106,589,402.3
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	100,000,000.0	0.0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	170,924,936.0	58,842,982.0
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	58,806,558.5	47,746,420.3
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	498,183,300.0	758,265,500.0
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	498,183,300.0	758,265,500.0
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	699,077,516.2	728,102,414.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	699,077,516.2	728,102,414.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	611,893,818.2	718,817,414.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	236,110,763.2	457,809,085.4
210101	Үндсэн цалин	179,920,037.1	283,070,988.6
210102	Нэмэгдэл	35,343,005.0	118,944,567.6
210103	Унаа хоолны хөнгөлөлт	342,000.0	0.0
210104	Урамшуулал	20,505,721.1	55,793,529.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	30,039,200.0	57,948,773.4
210201	Тэтгэврийн даатгал	20,592,000.0	39,398,281.3
210202	Тэтгэмжийн даатгал	2,361,900.0	4,637,623.1
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,889,500.0	3,710,158.4
210204	Ажилгүйдлийн даатгал	474,161.7	927,464.6
210205	Эрүүл мэндийн даатгал	4,721,638.3	9,275,246.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	57,621,370.5	75,657,446.7
210301	Гэрэл, цахилгаан	14,577,868.0	20,366,058.7
210302	Түлш, халаалт	42,793,502.5	54,991,388.0
210303	Цэвэр, бохир ус	250,000.0	300,000.0
2104	Хангамж, бараа материалын зардал	26,073,260.0	38,818,100.0
210401	Бичиг хэрэг	1,737,060.0	3,159,300.0
210402	Тээвэр, шатахуун	14,771,000.0	17,260,600.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,808,900.0	2,743,000.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	7,756,300.0	15,655,200.0
2105	Нормативт зардал	0.0	1,300,000.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	0.0	1,300,000.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,293,200.0	3,599,660.0
210604	Урсгал засвар	8,293,200.0	3,599,660.0
2107	Томилолт, зочны зардал	2,939,000.0	4,394,000.0

210702	Дотоод албан томилолт	2,939,000.0	4,394,000.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	42,308,756.6	12,724,063.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	40,797,353.6	10,949,100.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432,000.0	932,000.0
210803	Даатгалын үйлчилгээ	399,425.0	318,375.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	399,978.0	378,638.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	280,000.0	145,950.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	208,508,268.0	66,566,286.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	208,508,268.0	66,566,286.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	87,183,698.0	9,285,000.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	87,183,698.0	9,285,000.0
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	7,343,200.0	0.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	11,282,500.0	0.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	68,557,998.0	9,285,000.0
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	128,837,278.2	136,752,487.8
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	78,371,900.0	107,389,155.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	78,371,900.0	107,389,155.0
2200	Дотоод эх үүсвэрээр	78,371,900.0	107,389,155.0
223001	Бусад хөрөнгө	19,510,000.0	30,545,255.0
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	58,861,900.0	76,843,900.0
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-78,371,900.0	-107,389,155.0
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	50,465,378.2	29,363,332.8
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	0.0

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	733,779,241.5	381,560,151.9	9,816,980,667.1	10,932,320,060.6
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	733,779,241.5	381,560,151.9	9,816,980,667.1	10,932,320,060.6
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	(671,822,454.3)	(671,822,454.3)
C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	733,779,241.5	381,560,151.9	9,145,158,212.8	10,260,497,606.3
D01	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	733,779,241.5	381,560,151.9	9,145,158,212.8	10,260,497,606.3
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	733,779,241.5	381,560,151.9	9,145,158,212.8	10,260,497,606.3
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(868,283,102.8)	(868,283,102.8)
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	733,779,241.5	381,560,151.9	8,276,875,110.0	9,392,214,503.5

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	759,228,200.0	735,006,449.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	753,228,200.0	714,006,449.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	752,228,200.0	713,006,449.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	437,333,900.0	431,399,524.7
210101	Үндсэн цалин	361,971,500.0	279,414,352.8
210102	Нэмэгдэл	75,362,400.0	96,191,642.7
210104	Урамшуулал	0.0	55,793,529.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	54,741,900.0	54,719,735.4
210201	Тэтгэврийн даатгал	37,224,700.0	37,202,535.4
210202	Тэтгэмжийн даатгал	4,379,300.0	4,379,300.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,503,500.0	3,503,500.0
210204	Ажилгүйдлийн даатгал	875,800.0	875,800.0
210205	Эрүүл мэндийн даатгал	8,758,600.0	8,758,600.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	88,684,500.0	75,657,446.7
210301	Гэрэл, цахилгаан	13,245,600.0	20,366,058.7
210302	Түлш, халаалт	75,126,500.0	54,991,388.0
210303	Цэвэр, бохир ус	312,400.0	300,000.0
2104	Хангамж, бараа материалын зардал	88,684,500.0	75,657,446.7
210401	Бичиг хэрэг	13,245,600.0	20,366,058.7
210402	Тээвэр, шатахуун	75,126,500.0	54,991,388.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	312,400.0	300,000.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	15,700,000.0	15,655,200.0
2105	Нормативт зардал	1,300,000.0	1,300,000.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,300,000.0	1,300,000.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,300,000.0	2,299,660.0
210604	Урсгал засвар	2,300,000.0	2,299,660.0
2107	Томилолт, зочны зардал	5,685,000.0	4,394,000.0
210702	Дотоод албан томилолт	5,685,000.0	4,394,000.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	16,612,000.0	15,900,163.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	14,500,000.0	14,125,200.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	932,000.0	932,000.0
210803	Даатгалын үйлчилгээ	500,000.0	318,375.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	400,000.0	378,638.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	280,000.0	145,950.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	109,708,000.0	91,517,820.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	109,708,000.0	91,517,820.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,000,000.0	1,000,000.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,000,000.0	1,000,000.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.0	1,000,000.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	6,000,000.0	21,000,000.0
2200	Дотоод эх үүсвэрээр	6,000,000.0	21,000,000.0
222001	Тоног төхөөрөмж	0.0	15,000,000.0
223001	Бусад хөрөнгө	6,000,000.0	6,000,000.0
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	758,265,500.0	758,265,500.0
132001	Орон нутгийн төсвөөс	758,265,500.0	758,265,500.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	2022 он	2023 он
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	287,062,674.18	100,485,119.67
21	УРСГАЛ ЗАРДАЛ	287,062,674.18	75,939,864.67
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	196,585,974.18	63,254,864.67
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	0.00	26,409,560.71
210101	Үндсэн цалин	0.00	3,656,635.80
210102	Нэмэгдэл	0.00	22,752,924.91
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	0.00	3,229,037.96
210201	Тэтгэврийн даатгал	0.00	2,195,745.81
210202	Тэтгэмжийн даатгал	0.00	258,323.05
210203	ҮОМШӨ-ний даатгал	0.00	206,658.43
210204	Ажилгүйдлийн даатгал	0.00	51,664.61
210205	Эрүүл мэндийн даатгал	0.00	516,646.06
2104	Хангамж, бараа материалын зардал	3,281,400.00	3,000,000.00
210402	Тээвэр, шатахуун	3,281,400.00	3,000,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,147,000.00	1,300,000.00
210604	Урсгал засвар	1,147,000.00	1,300,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,094,356.18	573,900.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,094,356.18	573,900.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	191,063,218.00	28,742,366.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	191,063,218.00	28,742,366.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	90,476,700.00	12,685,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	90,476,700.00	12,685,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	7,343,200.00	0.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	83,133,500.00	12,685,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.00	24,545,255.00
2200	Дотоод эх үүсвэрээр	0.00	24,545,255.00
223001	Бусад хөрөнгө	0.00	24,545,255.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	328,403,598.17	106,589,402.29
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	328,403,598.17	106,589,402.29
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	100,000,000.00	0.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	170,924,936.00	58,842,982.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	57,478,662.17	47,746,420.29

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төв аймгийн Алтанбулаг сумын ЗДТГ нь сумын ИТХ, Засаг даргын бодлого боловсруулж, шийдвэр гаргахад нь бүх талын дэмжлэг туслалцаа үзүүлэх замаар төрийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай хүргэн төрийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, иргэдийн ажиллах амьдрах таатай орчин бүрдүүлэх, оновчтой бодлого зохицуулалтаар хангах замаар аймгийнхаа хөгжилд дэмжлэг үзүүлж чаддаг, цомхон чадварлаг, эцсийн үр дүнг эрхэмлэн дээдэлсэн төрийн албыг төлөвшүүлэх чиг үүрэг бүхий Аймгийн Засаг даргын харьяа байгууллага юм.

2023 оныг “Иргэдэд эрүүл, аюулгүй орчинг бүрдүүлэх, төрийн үйлчилгээг чанартай шуурхай хүргэх, төрийн албан хаагчийн ёс зүй, сахилга хариуцлагыг чангатган манлайлан ажиллах” зорилго дэвшүүлэн 11 зорилт, 42 ажил, арга хэмжээг төлөвлөн ажилласан. Дэвшүүлсэн зорилго, зорилт, арга хэмжээг 97,9 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжүүлж ажилласан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Төв аймгийн Алтанбулаг сумын ЗДТГ-ын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Харьяалах нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн хөгжлийн стратегийн төлөвлөлт, хөтөлбөр, төсөл зохиох, зохицуулах, хяналт шинжилгээ хийх, үнэлж дүгнэх, бодлогын удирдамжаар хангах,
- Засаг даргаас бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь зохион байгуулалт, эрх зүй, аж ахуйн талаар болон Тамгын газрын хэлтэс, албадын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах,
- Нутгийн захиргааны байгууллагыг чиглүүлэн удирдахад нь Засаг даргад туслах, Хурал, Засаг дарга, доод шатны нутгийн захиргааны байгууллагыг шаардлагатай мэдээллээр хангах, хууль тогтоомж, Засгийн газар, Хурал, Засаг даргын шийдвэрийг биелүүлэх үүрэг бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх, хэрэгжилтийг зохион байгуулах, гүйцэтгэлд нь хяналт тавьж үр дүнг тооцох
- Тамгын газрын бичиг хэргийг хөтлөх, байгууллага, иргэдээс ирүүлсэн өргөдөл, санал, гомдлыг шийдвэрлэх ажлыг зохион байгуулах, төрийн захиргааны ажилтныг бэлтгэх, давтан сургах, мэргэшүүлэх, тэдний ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах ажлыг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулах

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 15 дугаар зүйл “Нэгжийн эдийн засгийн үндсийг бүрдүүлэх төр орон нутгийн удирдлага”, 20 дугаар зүйл “Орон нутгийн чиг үүрэг”, 35 дугаар зүйл “Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бүрэн эрх”, мөн Төсвийн тухай хуулийн зарим зүйл заалт тухайлбал 8 дугаар зүйл “Төсвийн цагалбар”, 23 дугаар зүйл “Төсвийн орлого”, 24 дүгээр зүйл “Төсвийн зарлага”, 27 дугаар зүйл “Төсвийн төсөлд тавигдах шаардлага”-д өөрчлөлт орсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна. Тус байгууллагын дотоод хяналтыг төрийн сангийн мэргэжилтэн нь хариуцан гүйцэтгэдэг бөгөөд хараат байдалтайгаар ажиллаж байна.

Төв аймгийн Алтанбулаг сумын ЗДТГ нь дотоод аудитын нэгжгүй бөгөөд Аймгийн засаг даргын дэргэдэх Санхүү хяналт, аудитын алба хариуцан гүйцэтгэж байна. 2023 онд тус байгууллагын үйл ажиллагаанд Санхүү хяналт, аудитын албанаас аудит хийгээгүй тул дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино. Төв аймгийн Алтанбулаг сумын ЗДТГ-ын 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг Санхүү төрийн сангийн хэлтсийн 2012 оны "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг мөрдөн ажиллаж байна. Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Алтанбулаг сумын ЗДТГ-ын 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 868,283.1 мянган төгрөгөөр буюу 8,5 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
А	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	159,000.0	22,000.0	(137,000.0)
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	74,588.5	107,000.9	32,412.4
Үндсэн хөрөнгө	10,026,909.1	9,263,213.6	(763,695.5)
Нийт хөрөнгө	10,260,497.6	9,392,214.5	(868,283.1)
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	10,260,497.6	9,392,214.5	(868,283.1)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	10,260,497.6	9,392,214.5	(868,283.1)

Авлага дансны хувьд эрүүл мэндийн барилгын өргөтгөлийн ажлыг хүлээж авсантай холбоотой эхний үлдэгдлийн 150,000.0 мянган төгрөгөөр буурч, зөвлөхийн үйлчилгээний урьдчилгаа төлбөр 13,000.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

Бараа материал дансны хувьд тусгай зориулалтын материал 17,000.0 мянган төгрөг, аж ахуйн материал 15,412,367.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна. Шувууны суулт 10,000.0 мянган төгрөг, ангилан ялгах хогийн сав 11,700.0 мянган төгрөг, модны суулгац 4,000.0 мянган төгрөг, өвс тэжээл 26,490.0 мянган төгрөгөөр орлого авсан нь бараа материалын үлдэгдэл 32,412.4 мянган төгрөгөөр өсөхөд нөлөөлсөн байна.

Үндсэн хөрөнгө данс 2023 онд барилга байгууламж, орон сууц 300,789.0 мянган төгрөг, тээврийн хэрэгсэл 30,000.0 мянган төгрөг, машин тоног төхөөрөмж 28,339.0 мянган төгрөгөөр нэмэгдэж, акталсан 14,422.0 мянган төгрөгөөр буурсан байна. Тайлант онд 1258,266.4 мянган төгрөгийн элэгдэл байгуулсан нь үндсэн хөрөнгийн үлдэгдэл 763,695.5 мянган төгрөгөөр буурахад нөлөөлсөн байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 740,974.1 мянган төгрөг, нийт зарлагыг 740,974.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас үндсэн үйл ажиллагааны зардлыг 10,000.0 мянган төгрөгөөр бууруулан баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг шилжих 75,0974.1 төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 9 арга хэмжээг санхүүжүүлэхээр орон нутгийн төсвөөс 758,265.5 мянган төгрөгийг санхүүжихээр баталсан байна. Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 758,265.5 мянган төгрөг буюу 100,0 хувь санхүүжилт олгосон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 735,006.4 мянган төгрөг буюу 96,8 хувьтай байгаа нь цалин хөлс болон урамшил 5,934.4 мянган төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой зардлыг 13,027.1 мянган төгрөгөөр, бусад бараа ажил үйлчилгээний зардлыг 5,260.3 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага-Үндсэн үйл ажиллагааны зардал	555,676.00	555,676.00	-	100.0
2	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага-Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ	71,237.60	71,237.60	-	100.0
3	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага-Баг, хорооны үйл ажиллагааны зардал	67,943.90	67,943.90	-	100.0
4	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага-Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	1,000.00	1,000.00	-	100.0
5	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага-Бусад	21,000.00	21,000.00	-	100.0
6	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага-Орон нутгийн нөөц хөрөнгө	5,000.00	5,000.00	-	100.0
7	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага-Улсын их баяр наадам	5,000.00	5,000.00	-	100.0
8	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага-Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх	15,708.00	14,408.00	1,300.00	91.7
9	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага-Хур хог хаягдал, орчны бохирдлыг устгах, цэвэрлэх үйлчилгээ	15,700.00	15,655.20	44.80	99.7
	Дүн	758,265.50	756,920.70	1,344.80	99.8

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төв аймгийн Алтанбулаг сумын ЗДТГ нь 2023 онд нэмэлт санхүүжилтийн дансанд албан хаагчдын орон нутгийн нэмэгдэл болон санхүүжилт 70,970.3 мянган төгрөг, өвс тэжээлийн үнэ 9,201.5 мянган төгрөг, мал тооллогын 1,352.4 мянган төгрөг, чийрэгжүүлэлтийн талбайн ажлын санхүүжилт 24,545.3 мянган төгрөг, бусад 520.0 мянган төгрөг нийт 106,589.4 мянган төгрөгийн орлого орж, албан хаагчдад 29,638.6 мянган төгрөгийн орон нутгийн нэмэгдэл, өвс, тэжээлд 26,940.0 мянган төгрөг, сургалтын, зөвлөгөөний арга хэмжээнд 3,500.0 мянган төгрөг, шатахуунд 3,784.1 мянган төгрөг, чийрэгжүүлэлтийн талбай, тоног төхөөрөмж бусад арга хэмжээнд 30,399.8 мянган төгрөг зарцуулж, 12,208.6 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хэрэгжих хугацаанд нийт 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	70106 /Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага/-80101 /Үндсэн үйл ажиллагааны зардал	2023.01.01 2023.12.31	оныг "Иргэдэд эрүүл аюулгүй орчинг бүрдүүлэх, төрийн үйлчилгээг чанартай шуурхай хүргэх, төрийн албан хаагчийн ёс зүй, сахилга хариуцлагыг чангатган манлайлан ажиллах" зорилго дэвшүүлэн 11 зорилт, 42 ажил, арга хэмжээг хэрэгжүүлэх	Хэрэгжилт 100	555,676.00	555,676.00
2	70106 /Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага/-80103 /Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ	2023.01.01 2023.12.31	Байгууллагын хэвийн үйл ажиллагааг явуулахад шаардлагатай гэрээт ажилчдын цалин хөлс болон нэмэгдэл	Хэрэгжилт 100	71,237.60	71,237.60
3	70106 /Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага/-80106 /Баг, хорооны үйл ажиллагааны зардал	2023.01.01 2023.12.31	Сумын багийн иргэдэд төрийн үйлчилгээг хүргэх, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх	Хэрэгжилт 100	67,943.90	67,943.90
4	70106 /Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага/-80802 /Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	2023.01.01 2023.12.31	Хөдөлмөрийн дотоод журамд нөхцөл	Хэрэгжилт 100	1,000.00	1,000.00
5	70106 /Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага/-80918 /Бусад	2023.01.01 2023.12.31	Байгууллагын хэвийн үйл ажиллагааг явуулахад шаардлагатай тоног төхөөрөмж	Хэрэгжилт 100	21,000.00	21,000.00
6	70106 /Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага/-81102 /Орон нутгийн нөөц хөрөнгө	2023.01.01 2023.12.31	Байгаль орчны нөлөөллийг бууруулах, чадварыг нэмэгдүүлэх	Хэрэгжилт 100	5,000.00	5,000.00
7	70106 /Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага/-82801 /Улсын их баяр наадам	2023.01.01 2023.12.31	Сумын баяр наадмыг тэмдэглэн өнгөрүүлэх	Хэрэгжилт 100	5,000.00	5,000.00
8	70106 /Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага/-81701 /Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх	2023.01.01 2023.12.31	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага-Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх		15,708.00	14,408.00
9	70106 /Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага/-82212 /Хур хог хаягдал, орчны бохирдлыг устгах, цэвэрлэх үйлчилгээ	2023.01.01 2023.12.31	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага-Хур хог хаягдал, орчны бохирдлыг устгах, цэвэрлэх үйлчилгээ		15,700.00	15,655.20
Дүн					758,265.50	756,920.70

Хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 1 хөтөлбөр, арга хэмжээг 97,9 хувьтай хийж гүйцэтгэсэн байна.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Төв аймгийн Алтанбулаг сумын ЗДТГ-ын 2023 онд төсвийн хөрөнгөөр Саммит ХХК-иас 2,399.9 мянган төгрөг, GSDB Line ХХК-иас 8,113.5 мянган төгрөг, Майтеч ХХК-иас 600.0 мянган төгрөг, ЭЧМ ХХК-иас 20,000.0 мянган төгрөг, Говь хангай мебель ХХК –иас 4,453.0 мянган төгрөг, Ай Ти Зон ХХК-иас 18,030.0 мянган төгрөг, Грандворк интернэшил ХХК-иас 769.5 мянган төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авсан байна. Үүнээс цахим дэлгүүрээс 20,429.9 мянган төгрөгийн худалдан авалт хийсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Алтанбулаг сумын ЗДТГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах төрийн хэмнэлтийн тухай хэрэгжилттэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Бямбацогт гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Алтанбулаг сумын ЗДТГ-ын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн №01/05 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны үр дүнгийн тайлангийн орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны үр дүнгийн тайлангийн орлого 1,223,992.8 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 18,359.9 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 12,851.9 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тус байгууллага ажлын төлөвлөгөө гаргаж ажиллаагүй, гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаагүй байна. Үндсэн үйл ажиллагааны батлагдсан төсвөөс цалингийн зардал 5,934.4 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой зардал 13,027.1 мянган төгрөг, бусад зардал 5,260.3 мянган төгрөг, нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлсэн зардлын эх үүсвэрээс 6,104.3 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна. Төрийн хэмнэлтийн тухай хууль заасан арга хэмжээнд зардал гаргаагүй ба байгууллагын бүртгэлтэй автотээврийн хэрэгслийн улсын дугаарыг ялгах дэвсгэр бүхий дугаараар сольсон байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг

стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Төв аймгийн Алтанбулаг сумын ЗДТГ-ын шилэн дансны хуулийн хэрэгжилтэд аудит хийхэд 5.0 саяас дээших орлогын 19 гүйлгээ, зарлагын 23 гүйлгээ, 5.0 саяас дээших худалдан авалттай холбоотой 21 гүйлгээг хугацаандаа байршуулахаас 9 сард төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн мэдээ, хагас жилийн санхүүгийн тайлан, дараа жилийн төсвийн төслийг хугацаа хоцроож байршуулсан байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

2023 онд тус байгууллагын үйл ажиллагаанд завсрын аудит хийгээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Төв аймгийн Алтанбулаг сумын ЗДТГ-ын 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар 180.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 200,453.1 мянган төгрөгийн 2 албан шаардлага, 589,324.0 мянган төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж өгсөн байна. Зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилтийг 2023 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн №02/34 дугаарын албан бичгээр ирүүлсэн байна. 2023 оноос эхлэн төрийн сангийн программ нь гүйлгээг нэхэмжлэх эхэлж үүссэний дараа хийдэг болсон нь цахим төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй зөрчил буурах үндэс болсон байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	180.0	1	180.0	100
Албан шаардлага	2	200,453.1	2	200,453.1	100
Зөвлөмж	1	589,324.0	1	589,324.0	100
Нийт дүн	4	789,957.1	4	789,957.1	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Цалингийн зардлын гүйцэтгэл, авлагын үлдэгдэл, бараа материалын бүртгэл, түүнд тавих хяналтын талаар авч үзэхээр шийдвэрлэсэн.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 558,505.8 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 558,505.8 мянган төгрөгийн алдааг залрууллаа.

Залруулсан алдаа:

- Төсвийн зарцуулагдаагүй 30,708.1 мянган төгрөгийн үлдэгдлийг төвлөрүүлэхдээ НББ-ийн дансны бичилт буруу хийсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, санхүүгийн тайлангийн “үнэлгээ ба хуваарилалт” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- Мөнгөн гүйлгээний журналд 136,119.0 мянган төгрөгийн ажил гүйлгээг давхардуулан бичиж тайлагнасан, цалингийн урьдчилгаа 10,100.0 мянга төгрөгийг суутгаж хаахдаа цалингийн урьдчилгаа дансанд давхар бүртгэсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, санхүүгийн тайлангийн “үнэлгээ ба хуваарилалт” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- Төсвийн төлөвлөгөө, гүйцэтгэл, ерөнхий дэвтэр, ерөнхий журнал, үр дүнгийн тайлан, мөнгөн гүйлгээний журнал, Е тайлан дахь дансдын мөнгөн дүнг 381,578.6 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, санхүүгийн тайлангийн “үнэлгээ ба хуваарилалт” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар нийт 706,283.4 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс, 8,854.8 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 16,540.1 мянган төгрөгийн 2 албан шаардлага, 680,888.5 мянган төгрөгийн 3 зөвлөмж хүргүүлээ.

5.1 Төлбөрийн акт

Төв аймгийн Засаг даргын 2023 оны 01 дүгээр сарын 20-ний өдрийн Б/02 тоот захирамж, Алтанбулаг сумын Засаг даргын 2023 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн А/09 захирамжийн дагуу сумын төрийн улс төрийн албан хаагчийн орон нутгийн нэмэгдлийг төсөвтөө багтаан шийдвэрлэх гэсэн дагуу 6 албан хаагчдад орон нутагт ажилласны нэмэгдэлд 8,854.8 мянган төгрөг олгосон байна. Энэ нь Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 489 дүгээр “Тогтоолд нэмэлт оруулж, тогтоолын хавсралтад нэмэлт өөрчлөлт оруулах тухай” тогтоол, 2018 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 382 дугаар “Журам батлах тухай” тогтоол болон санхүүгийн тайлангийн аудитын “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь заалт болон МУЕА-ын 2020 оны а/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх,

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.3 "цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон" бол төлбөрийн акт тогтооно гэсэн заалтыг үндэслэн шийдвэрлэв.

5.2 Албан шаардлага

ХААН банкны 5724092427 дугаарын харилцах данс болон кассын 1,668.9 мянган төгрөгийн ажил гүйлгээ бүртгээгүй, урьдчилгаа төлбөр 9,926.1 мянган төгрөгийг өглөг дансанд бүртгэсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэсэн заалтыг болон санхүүгийн тайлангийн "иж бүрэн байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх заалт болон МҮЕА-ын 2020 оны а/95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.1-д "нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж баталгаажуулаагүй" бол албан шаардлага өгөх гэсэн заалтыг үндэслэн шийдвэрлэв.

Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас тоног төхөөрөмж, санхүүгийн программ, урсгал засварын зардалд 4,945.1 мянган төгрөг гаргасан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаал "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар" болон санхүүгийн тайлангийн "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх заалт болон МҮЕА-ын 2020 оны а/95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.1-д "нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж баталгаажуулаагүй" бол албан шаардлага өгөх гэсэн заалтыг үндэслэн шийдвэрлэв.

5.3 Зөвлөмж

1. Дотоод хяналттай холбоотой асуудал

Харилцагч байгууллага, иргэнтэй хийсэн худалдан авалтыг төлбөрийн цахим баримт, нэхэмжлэхийн дүнтэй тулгалт хийхэд 2,201.1 мянган төгрөгөөр зөрүүтэй байна. Энэ нь Сангийн сайдын 347 дугаар тушаалын "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар"-ын 5-д "Төлбөрийн баримт" заалтыг болон санхүүгийн тайлангийн "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төсвийн хөрөнгөөр худалдан авсан бараа, ажил үйлчилгээ бүрийг цахим баримтаар баталгаажуулах

2. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн хэрэгжилт

Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 678,687.4 мянган төгрөгийн өртөгтэй үндсэн хөрөнгө бүртгэлтэй байна. Энэ нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолын 7-д "Хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох" тухай заалтыг болон санхүүгийн тайлангийн "Үнэлгээ ба хуваарилалт" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Элэгдлээ анхны өртгөө нөхсөн хөрөнгийг цаашид ашиглах боломжтой бол дахин үнэлэх, боломжгүй бол эрх бүхий байгууллагад уламжлан шийдвэрлүүлэх.

3. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн хэрэгжилт

Үндсэн хөрөнгийн барилга байгууламжийн тоог газар эзэмших эрхийн бүртгэлтэй тулгахад зөрүүтэй, газар эзэмших эрхгүй, кадастрын зураг хийлгээгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, санхүүгийн тайлангийн “үнэлгээ ба хуваарилалт” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Газрын асуудал хариуцсан байгууллад уламжлан байгууллагын эзэмшиж байгаа газрын эрх, кадастрыг гаргуулж бүртгэх

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасан хугацаанд ирүүлж, төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг 2024 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс	
							Залруулсан	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Төсвийн зарцуулагадаагүй үлдэгдлийг төвлөрүүлэхдээ НББ-ийн дансны бичилт буруу хийсэн	1	30,708.1			1	30,708.1	1	30,708.13
Мөнгөн гүйлгээний журналд ажил гүйлгээг давхардуулан бичиж тайлагнасан	1	136,119.0			1	136,119.0	1	136,119.02
Цалингийн урьдчилгааг суутгаж хаахадаа цалингийн урьдчилгаа дансанд давхар бүртгэсэн байна.	1	10,100.0			1	10,100.0	1	10,100.00
Тайлант онд 32,450.0 мянган төгрөгийн өртөгтэй шинээр нэмэгдсэн 2 үндсэн хөрөнгөнд элэгдэл тооцоогүй байна.	1	456.2			1	456.2	1	456.22
Төсвийн төлөвлөгөө, гүйцэтгэл, ерөнхий дэвтэр, ерөнхий журнал, үр дүнгийн тайлан, мөнгөн гүйлгээний журнал, У тайлан дахь дансдын мөнгөн дүнг зөрүүтэй тайлагнасан байна	1	381,578.6			1	381,578.6	1	381,578.61
Дүн	5	558,962.0	0	0.0	5	558961.98	5	558,961.98

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо
Харилцагч байгууллагатай хийсэн худалдан авалтыг цахим төлбөрийн баримтын дүнтэй тулгахад зөрүүтэй байна.	1	2,201.1					1	2,201.1		
ХААН банкны 5724092427 дугаарын харилцах данс болон кассын ажил гүйлгээг бүртгээгүй, урьдчилгаа төлбөрийн өглөг дансанд бүртгэсэн байна	1	11,595.0			1	11,595.00				
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас тоног төхөөрөмж, санхүүгийн программ, урсгал засврын зардал гаргасан байна.	1	4,945.1			1	4,945.10				
Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 678,687.4 мянган төгрөгийн өртгөтэй 162 ширхэг үндсэн хөрөнгө бүртгэлтэй байна.	1	678,687.4					1	678,687.4		
Биет бус хөрөнгөнд бүртгэлтэй байгаа газар эзэмших эрхийг үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй байгаа барилга, байгуулалмжтай тулгахад дутуу бүртгэсэн байна	1	0.0					1	0.0		
Улс төрийн албан хаагчдад орон нутгийн нэмэгдэлд олгосон байна	1	8,854.8	1	8,854.8						
Дүн	6	706,283.4	1	8,854.8	2	16,540.10	3	680,888.5	-	-